

- Айл өрхийг дулааны шугамд холбох ажлыг эхлүүлэх

## ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?


Төсөл арга хэмжээнд хамруулах

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулан дэмжлэг үзүүлэх

Төрийн болон хувийн аж ахуй нэгжүүдийн ажлын байраар хангах

Төрийн албан хаагчдад цалингийн 50 хувийн нэмэгдлийг орон нутгийн төсвөөс батлуулан олгож байна.

Сумын хэмжээнд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд шинэ суурьшлын бүсийг нэмэгдүүлэн батлахаар ажиллаж байна.



ХҮДЭР СУМ



99023285



<http://khuder.se.gov.mn/>



# НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



“СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ”

Сэлэнгэ аймгийн Хүдэр сум нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 202 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Ерөө сум САА-н үр тарианы 3-р тасгийг түшиглэн улсын фондын хадлан тэжээл бэлтгэх зорилготой Тэжээлийн Аж Ахуй хэмээн байгуулагдсанаар үндэс суурь нь тавигдсан.





Тус сум нь 2672,9 га газар нутагтай, засаг захиргааны 2 нэгжтэй, 2936 хүн амтай, 845 өрхтэй. Улаанбаатар хотоос 420 км, аймгийн төвөөс 168 км зайд оршдог. Баруун талаараа Сэлэнгэ аймгийн Ерөө сум, баруун хойд талаараа Алтанбулаг сум, хойд талаараа ОХУ-тай, зүүн болон өмнө талаараа Хэнтий аймагтай хиллэдэг. Сумын нутаг дэвсгэрийн 57,3 хувийг ой мод эзэлдэг бөгөөд уулархаг, хар шороон хөрстэй.

Төмрийн хүдэр, нүүрс, алт зэрэг байгалийн баялаг ихтэйгээс гадна хүн ардын хүнсний болон эмчилгээнд хэрэглэдэг гүзээлзгэнэ, үхрийн нүд, улаалзгана, мойл, үрэл гэх мэт жимс жимсгэнэ бадааны үндэс, егүүшин, нохойн хошуу зэрэг эмийн болон ургамал элбэгтэй. Хангайн болон тайгын бүслүүрийн шилмүүст, навчит ойд 10 гаруй төрлийн мод ургасан үзэсгэлэнт уул нуруудтай, буга, бор гөрөөс, хүдэр, гахай баавгай чоно, үнэг, төрөл бүрийн ан амьтан, жигүүртэн шувуудтай, байгалийн үзэсгэлэн төгс газар нутагтай

- ❖ УБ хот, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймагтай хатуу хучилттай замаар бүрэн холбогдсон
- ❖ Төвийн эрчим хүчинд холбогдсон
- ❖ Ашигт малтмал ихтэй /алт, төмрийн хүдэр, нүүрс, түгээмэл тархацтай ашигт малтмал/
- ❖ Ховор эмийн ургамал, самар жимс, ан амьтан элбэгтэй
- ❖ Ой модны нөөцтэй
- ❖ Хөрсний үржил шим сайтай
- ❖ Усны нөөц сайтай
- ❖ Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, өвс хадлангийн нөөцтэй
- ❖ Олон улсын чанартай авто зам, төмөр замд ойр
- ❖ Хилийн бүс нутагт оршдог

### СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Иргэд байгалийн нөөц баялаг, жимс жимсгэнэ, эмийн ургамал түүж ашиглах, хүнсний ногоо тариалах талаар уламжлагдан ирсэн арга туршлагатай бөгөөд өнөөгийн байдлаар сумын брэнд бүтээгдэхүүнээр жимсний чанамал, тагар сонгино, чаг мөөг, буриад талх зэрэг байгаа бөгөөд цаашид брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сүү цагаан идээ, мах боловсруулах цех, самрын үйлдвэр, зүймэл хавтан, мод модон эдлэлийн үйлдвэрлэл, амралт сувиллын газар байгуулах, эрчимжсэн мал аж ахуй, төмс хүнсний ногоо тариалах, мод үржүүлэг хөгжүүлэх

боломжтой.



Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет өв соёлыг хадгалан, нутгийн иргэдийг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Түүх соёлын үл хөдлөх газруудаар аялуулах маршрут гаргаж тайлбарт хөтөч ажиллуулах

Хүдэр сумын байгалийн өвөрмөц тогтоц бүхий "Соронзон хад"-ын байгаль экологийн онцлогийг хадгалж, хамгаалан тохижуулан ажиллахаар төлөвлөж байна.



Аялал жуулчлалын чиглэлээр Малчдыг түшиглэсэн аялал жуулчлал, амралт сувиллын бааз байгуулах, Явган аялал, өвлийн спортын болон ан агнуурын бааз байгуулах, экстрем аяллыг хөгжүүлэх, Жаргалант, Нумтын рашааныг түшиглэн мөн хусны шүүс, байгалийн эмчилгээний ургамалд тулгуурласан амралт сувиллын газрыг байгуулах

**ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:**

- Спорт заал баригдаж байна.
- Шинэ соёлын төв барих
- Бага сургууль барих

